



VII/2021

Тархаасан: 2021 оны 8 дугаар сарын 11




Агаарын үнэмлэхүй их температур 2021 оны 7 дугаар сард Баянхонгор аймгийн Шинэжинст суманд  $+40.1^{\circ}\text{C}$ -д хүрсэн байна

## Цаг агаар

Агаарын үнэмлэхүй их температур 2021 оны 7 дугаар сард Баянхонгор аймгийн Шинэжинст суманд  $+40.1^{\circ}\text{C}$ , үнэмлэхүй бага температур Баянхонгор аймгийн Галуут суманд  $0.8^{\circ}\text{C}$ -д хүрлээ.

ЗУРАГ 1. АГААРЫН ТЕМПЕРАТУР ( $^{\circ}\text{C}$ ), ОЛОН ЖИЛИЙН ДУНДАЖТАЙ<sup>1</sup> ХАРЬЦУУЛСНААР, станцын байршлаар, жил бүрийн 7 дугаар сарын байдлаар



<sup>1</sup> - 1981-2010 он

Цаг уур, орчны шинжилгээний газрын мэдээгээр 2021 оны 7 дугаар сард орсон хамгийн их хур тунадасны нийлбэр Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр суманд 208.3 мм-т хүрсэн байна. Үнэмлэхүй их салхины хурд Дундговь аймгийн Сайхан-Овоо суманд 34 м/с-д хүрсэн байна.


## Агаарын чанар

Улаанбаатар хотын агаар дахь хүхэрлэг хийн сарын хамгийн их агууламж 2021 оны 7 дугаар сард бүх станцуудад  $0.008\text{ мг/м}^3$  -  $0.096\text{ мг/м}^3$ -д хүрсэн бөгөөд 1-р хороолол, Амгалан орчимд  $0.069\text{ мг/м}^3$  -  $0.096\text{ мг/м}^3$ -д хүрч, агаарын чанарын хүлцэх агууламжаас  $0.019\text{ мг/м}^3$  -  $0.046\text{ мг/м}^3$ -аар давсан байна.

Азотын давхар ислийн сарын хамгийн их агууламж 2021 оны 7 дугаар сард бүх станцуудад 0.007 мг/м<sup>3</sup>–0.059 мг/м<sup>3</sup>-д хүрсэн бөгөөд Баруун дөрвөн зам орчимд 0.059 мг/м<sup>3</sup>-д хүрч, агаарын чанарын стандарт хүлцэх агууламжаас 0.009 мг/м<sup>3</sup>-ээр давсан байна.


Харин PM 10 тоосонцрын сарын хамгийн их агууламж 2021 оны 7 дугаар сард бүх станцуудад 0.017 мг/м<sup>3</sup> – 0.210 мг/м<sup>3</sup>-д хүрсэн бөгөөд Мишээл экспо, Баруун дөрвөн зам, Хархорин зах, 32-ын тойрог орчимд 0.101 мг/м<sup>3</sup> – 0.210 мг/м<sup>3</sup>-д хүрч, агаарын чанарын стандарт хүлцэх агууламжаас 0.001 мг/м<sup>3</sup> – 0.110 мг/м<sup>3</sup>-ээр давсан байна.

ЗУРАГ 2. УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ ХҮХЭРЛЭГ ХИЙН ДУНДАЖ АГУУЛАМЖ, жил бүрийн 7 дугаар сарын байдлаар, мг/м<sup>3</sup>



Улаанбаатар хотын агаар дахь азотын давхар ислийн дундаж агууламж 2021 оны 7 дугаар сард өмнөх оны мөн үеэс 0.006 мг/м<sup>3</sup> (21.8%)-аар, өмнөх сараас 0.004 мг/м<sup>3</sup> (15.8%)-ээр тус тус бага байна. Хүхэрлэг хийн дундаж агууламж өмнөх оны мөн үеэс 0.008 мг/м<sup>3</sup> (3.3 дахин)-аар, өмнөх сараас 0.001 мг/м<sup>3</sup> (11.6%)-аар, PM 10 тоосонцрын дундаж агууламж өмнөх оны мөн үеэс 0.008 мг/м<sup>3</sup> (19.0%)-аар, өмнөх сараас 0.006 мг/м<sup>3</sup> (14.0%)-оор тус тус их байна. Харин PM 2.5 тоосонцрын дундаж агууламж өмнөх оны мөн үеэс 0.003 мг/м<sup>3</sup> (19.1%)-ээр бага, өмнөх сараас 0.001 мг/м<sup>3</sup> (6.0%)-оор их байна.

ЗУРАГ 3. УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ БОХИРДУУЛАГЧ БОДИСУУДЫН САРЫН ДУНДАЖ АГУУЛАМЖ, жил бүрийн 7 дугаар сарын байдлаар, мг/м<sup>3</sup>



ХҮСНЭГТ 1. УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ БОХИРДУУЛАХ БОДИСЫН АГУУЛАМЖ АГААРЫН ЧАНАРЫН СТАНДАРТ ХҮЛЦЭХ АГУУЛАМЖААС ДАВСАН ТОХИОЛДЛЫН ТОО, станцаар, 2021 оны 7 дугаар сард

Станцын байршил	Хүхэрлэг хий (SO <sub>2</sub> )	Азотын давхар исэл (NO <sub>2</sub> )	Тоосонцор (PM 10)	Тоосонцор (PM 2.5)	Озон (O <sub>3</sub> )
Мишээл экспо	-	-	2	-	-
Баруун 4 зам	-	1	4	-	-
1-р хороолол	2	-	-	-	-
32-ын тойрог	-	-	11	-	-
Хархорин	-	-	10	-	-
Хайлааст	-	-	-	1	-
248-р цэцэрлэг	-	-	-	1	-
Нисэх	-	-	-	-	4
Зурагт	-	-	-	-	5
Амгалан	7	-	-	-	1

**Аюулт үзэгдэл, осол**

Аюулт үзэгдэл, ослын тохиолдол 2021 оны эхний 7 сард 2333 болж, өмнөх оны мөн үеэс 428 (15.5%)-гоор буурсан байна. Объектын түймэр 1521 удаа гарч, өмнөх оны мөн үеэс 558 (26.8%)-аар буурсан байна. 7-р сард 562 удаа аянга цахилгаан мөндөр ажиглагдаж, өмнөх сараас 255 (1.8 дахин)-аар нэмэгдсэн байна.

Улсын хэмжээнд 2021 оны эхний 7 сард мал, амьтны халдварт галзуу өвчний 18, шинэ төрлийн Корона вируст (Covid-19) халдварын 166842 тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.

ХҮСНЭГТ 2. АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ, жил бүрийн эхний 7 сарын байдлаар

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2018 I–VII	2019 I–VII	2020 I–VII	2021 I–VII	<u>2021 I–VII</u> 2020 I–VII	%
Аюулт үзэгдэл, ослын тохиолдол	тоо	2 949	3 403	2 761	2 333		84.5
Амь насаа алдсан хүн	тоо	120	146	161	1 092		6.8 <sup>1</sup>
Түлэгдсэн, бэртсэн, өвчилсөн хүн	тоо	38	42	345	166 893		483.7 <sup>1</sup>
Шатсан гэр, орон сууц	тоо	1 062	1 140	1 005	506		50.3
Объектын түймэр	тоо	2 333	2 885	2 079	1 521		73.2
Учирсан хохирол	тэрбум төгрөг	15.8	30.8	107.8	16.4		15.2
Зарцуулсан зардал	сая төгрөг	9 959.5	1 056.2	178.9	1 919.1		10.7 <sup>1</sup>

<sup>1</sup> - Дахин их

Аюулт үзэгдэл, ослын улмаас 2021 оны эхний 7 сарын байдлаар нийт 1092 хүн амь насаа алдаж өмнөх сараас 361 (1.5 дахин)-аар, 166893 хүн түлэгдэж, бэртэж, өвчилж, хордсон бөгөөд өмнөх сараас 53791 (1.5 дахин)-ээр нэмэгдсэн байна.

Бичил уурхай, нурангийн улмаас 5 хүн, усны ослоор 91 хүн, хүчтэй салхи, шуурганы улмаас 11 хүн, объектын түймрийн улмаас 38 хүн, шинэ төрлийн Корона вируст халдварын улмаас 920 хүн, бусад золгүй явдлын улмаас 27 хүн амь насаа алджээ.

Аюулт үзэгдэл, ослын улмаас 2021 оны эхний 7 сарын байдлаар 506 гэр, байшин, орон сууц шатаж, өмнөх оны мөн үеэс 499 (49.7%)-аар буурсан байна. Харин 16.4 тэрбум төгрөгийн хохирол учирч, 1.9 тэрбум төгрөг зарцуулсан байна.

Аюулт үзэгдэл, ослоос 2021 оны эхний 7 сарын байдлаар 2455 хүнийг аварч, 56.4 тэрбум төгрөгийн эд хөрөнгийг хамгаалсан байна.

#### **Ойлголт, тодорхойлолт:**

**Агаарын бохирдол:** Агаар мандалд нэг буюу хэд хэдэн химийн бодис дагнасан буюу хавсарсан байдлаар хүн, амьтан, ургамлын аймгийн амьдрал, ахуйн нөхцөл, үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл үзүүлж, стандартаар тогтоосон хүлцэх хэм хэмжээнээс давсан агаар дахь бохирдуулах бодис тодорхой хугацаагаар байхыг ойлгоно.

**Аюулт үзэгдэл:** Хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг ойлгоно.

**Гамшиг:** Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг ойлгоно.

**Зөвшөөрөгдөх түвшин:** Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь физикийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх түвшинг ойлгоно.

**Хүлцэх агууламж:** Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь химийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх хэмжээг ойлгоно.



**Эх үүсвэр:** Цаг уур, орчны шинжилгээний газар, Онцгой байдлын ерөнхий газар

#### **Мэдээлэл авах линкүүд:**

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

**Дараагийн мэдээ тархах хуваарь:** 2021 оны 9 дугаар сарын 15

Эдийн засгийн статистикийн  
газрын дарга Э.Эрдэнэсан  
Утас : (976-51)-266414

Эдийн засгийн статистикийн  
газрын статистикч Г.Цэвэлмаа  
Утас : (976-51)-261563

